

**Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын
Ажлын хэсгийн хурагдааны тэмдэглэл /2022-04-28/**

Ажлын хэсгийн 58 дугаар хуралдаан 2022 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 10.00 цагт цахим хэлбэрээр зохиогдов.

Ажлын хэсгийн хуралдаанд Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Батболд, ахлах шинжээч Д.Дамба, Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газрын мэргэжилтэн Ж.Ивээлэн, Татварын ерөнхий газрын байцаагч Ч.Батцэнгэл, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэргэжилтэн Д.Дамбасүрэн, Ашигт малтмал газрын тосны газрын мэргэжилтэн П.Золзаяа, Авилгатай тэмцэх газрын Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн зохицуулагч С.Дуламсүрэн, байцаагч Б.Ганхуяг, Нүүрс ассоциацийн Удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Эрдэнэцэцэг, Уул уурхайн ассоциацийн гүйцэтгэх захирал н.Эрдэнэтуяа, Оюутолгой ХХК-ийн ахлах менежер Т.Мөнхбат, Бороо гоулд ХХК-ийн татварын нягтлан бодогч Т.Мөнхзул, Рио Тинто Монгол ХХК-ны менежер Б.Даваасүрэн, Бадрах энерги ХХК-ны ЭМХАБОТХ-ийн асуудал хариуцсан захирал Ц.Энхжаргал, Петрочайна Дацан Тамсаг ХХК-ын ерөнхий нягтлан бодогч Ц.Болормаа, Нээлттэй нийгэм форумын менежер Д.Эрдэнэчимэг, Хүний эрх хөгжил төв ТББ-ын тэргүүн Г.Уранцоожийг орлож Хил хязгааргүй алхам ТББ-ын тэргүүн Н.Баярсайхан, Эрхүүгийн УАААДС-ийг төгсөгчдийн холбооны тэргүүн Л.Бямбажав, Захиргааны шинэ санаачилга ТББ-ийн тэргүүн Д.Цэрэнпүрэв, Ховдын толь ТББ-ын тэргүүн Г.Төрмөнх, Транспаренси Интернэйшнл Монгол байгууллагын ерөнхийлөгч Л.Төр-Од, менежер Мөнхжаргал, МБОИЗ-ын Удирдах зөвлөлийн гишүүн Ц.Бээжин, МБОИЗ-ын гүйцэтгэх захирал Т.Цэрэн болон Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга, ажлын албаны зохицуулагч Ш.Цолмон нар оролцов. Хуралд ажлын хэсгийн 33 гишүүнээс 26 гишүүн оролцож, ирц 78,8 хувьтай байв.

Мөн хуралдаанд Энержи ресурс ХХК-ны албаны дарга З.Сугармаа, ажилтан Сүрэн, ОҮЗСТ-ийн зохицуулагч З.Баярхүү, Мэдээлэл технологийн зөвлөх В.Нармандах, харилцааны мэргэжилтэн З.Цэлмэг, санхүүгийн ажилтан А.Отгонтунгалаг нар оролцов.

Хуралдааныг УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал нээж үг хэлэв.

Г.Нандинжаргал: Сайн байцгаана уу, Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Өнөөдөр бид Ажлын хэсгийнхээ 2022 оны анхны буюу 58-р хуралдаанаа цахимаар зохион байгуулж байна. Эдийн засгийг сэргээж, төсвийн зардлыг хэмнэх горимд шилжин, төсвийн тодотгол хийх замаар эдийн засгийн өсөлтийг хангах арга хэмжээ авч байгаа өнөөгийн шинэ нөхцөл байдалд зохицон ажиллахыг шаардаж байна. Хурлын хэлэлцэх асуудал, хөтөлбөрөө Ажлын албанаас Та бүхэнд урьдчилан цахимаар хүргүүлсэн бөгөөд материалуудтай танилцаж амжсан гэдэгт итгэлтэй байна. Хуралдаан маань ажил хэрэгч, бүтээлч уур амьсгалд явагдана гэдэгт гүнээ итгэж байна.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт:

- Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон

тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ.

- Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.
- 3.2.6. Уул уурхайн салбарын институцийг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгож, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно.-гэсэн зорилтуудыг Та бүхэндээ дахин сануулья.

Нөгөө талаас, 2022 оны “Баталгаажуулалт”-ын зөвлөмжүүдийг бүрэн хэрэгжүүлж, ОУИТБС-ын олон улсын стандартын шаардлага бүрийг хангахад бидний үйл ажиллагааны бас нэг чиглэл байх ёстой. Тэгэхээр ОУИТБС-ын оролцогч талууд маань үйл ажиллагаагаа эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхэд идэвхтэй хамтран ажиллахыг уриалж байна. 2022 оны хувьд Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хууль мөн Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу хэд хэдэн хуульд багц нэмэлт өөрчлөлт оруулж батлуулахаар төлөвлөөд байсан. Түүнчлэн, ОУИТБС болон Олборлох үйлдвэрлэлийн салбарын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, тайлан мэдээг ойлгомжтой байдлаар боловсруулж, түгээх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, дэд зөвлөлүүдийг чадавхжуулахад цаашид анхаарч ажиллах хэрэгтэй байна. За, ингээд хуралдааны үйл ажиллагаагаа эхлүүлье.

Хуралдааныг цаашид УУХҮЯ-ны Судалгаа, хөрөнгө оруулалтын газрын дарга Э.Батболд удирдаж явуулна.

Э.Батболд: За хурлын нээж өгсөн Нандинжаргал даргадаа баярлалаа. Хурлын хөтөлбөрийн дагуу нэгдүгээр танилцуулгыг ажлын албаны ОУИТБС-ын 2020 оны нэгтгэл тайлангийн танилцуулгыг сонсоно. Энэ жилийн тайлангийн онцлог нь ОУИТБС-ын стандартын дагуу уян хатан байдлаар хийлгэх ёстой.

Танилцуулга нэг: Монголын ОУИТБС-ын 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн явцын танилцуулга.

Ш.Цолмон: Сайн байцгаана уу, танилцуулгыг урьдчилан хүргүүлсэн тул товчхон танилцуулъя. Бид ОУИТБС-аас 2022 онд 77 нэрийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн. Үүнээс 27 ажлыг хэрэгжүүлсэн буюу хэрэгжүүлэлтийн түвшинд (35%) явагдаж байна. Дэлхийн банкнаас 2022-2023 онд 500 мян.ам.долларын төсөл хэрэгжүүлэхээр бэлтгэл хангаад байна. Мөн ХБНГУ-ын BGR төслийн хүрээнд ОУИТБС-ын цахим тайлагналын системийг сайжруулах төслийг хэлэлцэж байна. 2021 оны нэгтгэл тайланг боловсруулах компанийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулав.

Олборлох үйлдвэрийн компаниудыг ОУИТБС-ын 2021 оны тайланг гаргах ажлыг зохион байгуулав. 1592 компани тайлангаа гаргасан нь анх удаа хамгийн өндөр үзүүлэлт болсон. Төрийн өмчийн 15 аж ахуйн нэгж тайлангаа гаргасан бол газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт 8 компани тайлагнасан байна. Төрийн байгууллагуудын ОУИТБС-ын 2021 оны тайланг гаргах ажлыг эхлүүлээд байна. Одоогоор Баянгол дүүрэг л тайлангаа гаргасан байна.

Компаниудад 4 удаагийн сургалт, Орон нутгийн дэд зөвлөлд 4 сургалт семинарыг цахимаар зохион байгуулсан. ОУИТБС-ын цахим сайтыг шинэчилж, мэдээллийг баяжуулсан. 2022 оны 1-р сарын 1-нээс Баталгаажуулалт эхэлж, холбогдох 10 гаруй

уулзалтуудыг цахимаар зохион байгуулсан. Эцсийн өмчлөгчийн асуудлаар Ази, Номхон далайн бүсийн нутгийн цахим зөвлөгөөнийг зохион байгуулсан. Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хуулийн төслийг идэвхжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулж, холбогдох талуудтай зөвлөлдсөн байна.

2022 оны үлдсэн хугацаанд дараах ажлуудыг хийхээр төлөвлөөд байна. Монгол Улсын ОУИТБС-ын үнэлгээ гарна.(дутуу, засч сайжруулах ажлуудыг гүйцээх, хугацаатай зөвлөмж өгөх магадлалтай тул нэмэлт төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх)

Эцсийн өмчлөгчийн асуудлаар “Нээлттэй өмчлөгч” олон улсын байгууллага, ОУИТБС-ын ОУНБГ-тай хамтран УУХҮЯ дээр “Олборлох үйлдвэрлэлийг нээлттэй болгох” нь 5 жилийн хөтөлбөрийг үргэлжүүлэх, зохицуулагч ажиллуулах, мэдээлэл харилцааны үйл ажиллагааг шинэ шатанд гаргах, ОУИТБС-ын бүтцэд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж ажлын төлөвлөгөө боловсруулах, ОУИТБС-ын нээлттэй өгөгдлөөр хариуцлагатай 5-10 компанийн улс болон орон нутагт төлсөн татвар хураамж, хандив дэмжлэг, ажлын байр, олборлолт, борлуулалтын талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх (3-5 аймгийг сонгоно) Говийн бүсийн ил тод байдлын аяныг дүгнэх, Төв, Зүүн бүсийн аймгуудын дэд зөвлөлүүдийг хамруулах, Уламжлал ёсоор Бүсийн чуулгадыг шинэ арга барилаар зохион байгуулна. /танилцуулгыг хавсаргав/

Танилцуулга хоёр: “Олборлох үйлдвэрлэлийг нээлттэй болгох нь” олон улсын төслийн танилцуулга.

Ш.Цолмон: Энэ төслийн талаарх мэдээллийг 2021 онд гишүүдэд танилцуулсан тухайн үед оролцоо муу байсан учраас мэдлэг мэдээлэл дутуу байна. Иймд дахин мэдээлэл хүргэе. ОУИТБС-ын Олон Улсын НБГ, Нээлттэй Өмчлөл Олон Улсын байгууллага 2017 оноос энэ чиглэлээр хамтран ажиллаж байна. Харин 2021 оноос энэхүү хамтарсан төслийг эхлүүлсэн. Төсөл нь 5 жилийн хугацаатай, “БиЭчПи” сангаас санхүүжүүлж байна. Гана, Либери, Нигери, Сенегал, Замби, Армен, Индонез, Монгол, Филиппин, Украин, Аргентин, Колумб, Мексик гэсэн улсуудад хэрэгжүүлж эхлээд байна. Үндсэн зорилго нь Эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгон, мэдээллийн ашиглалтыг сайжруулах аргаар байгалийн баялаг бүхий орнуудын иргэд үр шимийг нь үнэмлэхүй хэмжээгээр ашиглах нөхцөл бололцоог бий болгоход дэмжлэг үзүүлэх, төслийн зорилт нь 1)Эцсийн өмчлөгчийн чанартай мэдээллийг ил тод болгоход ЗГ, Компаниудад туслах, 2)холбогдох талуудын чадавхийг нэмэгдүүлэх, 3)ил тод болгосны үр нөлөөг нэмэгдүүлэх, харилцааны арга зүйг хөгжүүлэх юм. Эцсийн өмчлөлийн ил тод байдлын шинэчлэлийн талаар авсан улс төрийн амлалт, оролцогч бүх талуудын оролцоог хангах ажлын хүрээнд Төрийн байгууллагуудын хэлэлцүүлэг зохион байгуулах; Бусад орнуудын туршлага судлах семинар зохион байгуулах; Эцсийн өмчлөлийн ил тод байдлыг хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд Эцсийн өмчлөлийн цахим сан бий болгох (санхүүгийн ил тод байдал, татвар, хөрөнгө г.м) ТЭЗҮ боловсруулах зэрэг саналуудыг оруулсан. Төслийн нээлтийн үйл ажиллагаа 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хийхээр урьдчилан товлон, бэлтгэл ажлыг хийж байна. Цахим болон танхимаар хосолсон арга хэмжээ зохион байгуулна. Мөн төслийн хүрээнд төслийн хэрэгжилтийг хангах богино хугацааны хуульч сонгон шалгаруулж, ажиллуулна. Тус арга хэмжээний хөтөлбөр болон бусад мэдээллийг танилцуулгаас харж болно. Зөвлөхийн ажлын даалгаврыг имэйлээр явуулна, танилцаад санал өгөөрэй. Баярлалаа. /Танилцуулгыг хавсаргав/

Мөн удахгүй хийгдэх ажлын нэмэлт мэдээлэл өгье. Энэ 5 дугаар сард ОУИТБС-ын Зүүн бүсийн чуулган хийнэ, ТАН эвслийн Бор гуайтай хамтран ажиллаж, Сүхбаатар аймгийн уулзалт, семинар хийхээр ярилцаж байгаа. Түүнчлэн УУХҮЯ-ны дэд сайдын өгсөн чиглэлийн дагуу Эдийн засгийн хүрээлэнтэй хамтран цахим тайлангаар гарч байгаа мэдээллийн ашиглалтыг сайжруулах талаар ажиллах санамж бичиг байгуулах, чиглэл тогтоохоор ажиллаж байна. Энэ чиглэлээр хамтран ажиллах гишүүд байвал нээлттэй гэдгийг хэлье.

Э.Батболд: Баярлалаа, гишүүдээс асуух асуултанд хариулна.

Д.Эрдэнэчимэг: Ажлын төлөвлөгөөний биелэлттэй холбоотой асуулт асууя. Г.Нандинжаргал дарга хурлын нээлтэнд үг хэлэхдээ: “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хуулийн” төсөл дээр ажиллаж байгаа гэсэн гэхдээ энэ хууль цаашаа явахааргүй болчихлоо. Энэ хаврын чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй, үүнийг урагшлуулах талаар яам ямар арга хэмжээ авч байна вэ? Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор иргэдийн байгалийн баялаг ашиглах, мэдэх эрхийн талаар шинээр тусгайлан оруулж ирсэн. Үүнийг хангах чиглэлээр яам ямар ажил хийж байна, юу нь болохгүй яагаад явахгүй байна вэ? Нөгөө талаар Ашигт малтмалын тухай хуулийн төсөл явж байгаа. Ил тод байдлын тухай хуулиа дангаар нь явуулж чадахгүй байгаа бол ядаж, Ашигт малтмалын тухай хуульд хаана нь хэрхэн тусгасан бэ? Ер нь тусаагүй гэдгийг би мэдэж л байгаа энэ талаар асуулт байна. Ил тод байдлын бие даасан хуультай болгох асуудал “Нээлттэй засаг түншлэл”-ийн 3 дугаар төлөвлөгөөнд орсон байсан, хэрэгжээгүй гээд бид олон улсаас шүүмжлэл авсан. 2021 оны 12 дугаар сард дөрөвдүгээр төлөвлөгөөнд оруулж, бие даасан хуультай болохоор батлагдсан байгаа. Энэхүү Нээлттэй засаглалын түншлэлийн төлөвлөгөө батлах ажлын хэсэгт УУХҮЯ-наас Д.Дамба гуай оролцсон. Энэ олон улсын өмнө хүлээсэн үүргээ хэзээ биелүүлэх вэ? яах юм бол? Одоо 5 дугаар сард олон улсын өдөр болно. Тэр өдөртэй холбоотойгоор олон улсын байгууллагаас өндөр хэмжээний уулзалт Монгол улсад хийх юм байна тэгэхээр яалт ч үгүй энэ асуудал сөхөгдөөд гараад ирнэ. Энэ талаар яамнаас хариулт авахыг хүсэж байна хэрвээ Нандинжаргал дарга байгаа бол өөрөө хариулахыг хүсэж байна.

Э.Батболд: Ил тод байдлын тухай хууль боловсрогдоод бэлэн болсон байгаа. Гагцхүү “толгой хууль” буюу Ашигт малтмалын тухай хуулийг батлуулсны дараа Ил тод байдлын тухай хуулийг өргөн барьж, батлуулах төлөвлөгөөтэй хүлээгдэж байна. Өөр шалтгаан байхгүй.

Д.Дамба: Батболд даргын хэлснээр хуулийн төсөл боловсруулагдаад дууссан. ОУИТБС-ын бүсийн чуулганд танилцуулга хийгдсэн байгаа. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга хийгдэж байгаа үүнтэй Ил тод байдлын тухай хуулиа нийцүүлэх гээд түр хүлээгдээд байгаа. Мөн Мэдээллийн ил тод байдлын тухай хуульд Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуультай холбоотой заалтууд орсон байгаа, ямар ч хуульгүй гэж болохгүй. Ер нь олон улсын стандартын шаардлагын дагуу хууль батлуулах ёстойг ойлгож байна. Манай улсын онцлог байна, бид Ашигт малтмалын тухай хуультайгаа уялдуулахаар хүлээгдэж байна гэж ойлгож болно.

Д.Эрдэнэчимэг: Юу гэсэн үг вэ бие даасан хуулийг явуулна гэсэн үг үү? явуулахгүй гэсэн үг үү?

Д.Дамба: Ер нь бие даасан хууль батлуулахаар боловсруулсан, өмнөх хурал семинарт танилцуулсан байгаа. УУХҮ-ийн сайд албан тушаалаараа ОУИТБС-ын

Үндэсний зөвлөлийг ахлаж байгаа иймд олон талын төлөөлөл хуулийн төслийн талаар сайдтай уулзаж, нэгдсэн ойлголтод хүрэх нь зүйтэй гэж бодож байна.

Т.Цэрэн: Одоогоор Ашигт малтмалын хуулийн төсөл боловсруулагдаж, санал авч байгаа юм байна. Бид үүнд оролцож болох уу? Бид мэдээгүй юм байна. Манай МБОИЗ нь 200 гаруй байгууллагын нэгдэл, ИНБ-ууд байдаг. Бидэнд хуулийн төсөлд санал авах мэдээлэл ирээгүй. Уул уурхайтай газруудад иргэд болон аж ахуйн нэгжүүдийн хооронд зөрчилдөөн гарч байгааг та бүхэн мэдэж байгаа. Энэ асуудлыг шийдэхэд ажлын хэсэг болон яамны зүгээс юу хийхээр төлөвлөж байна вэ? Сэлэнгийн Мандах, Баянхонгор аймгийн Шинэжинст сум, Өмнөговь аймгийн сумдаас янз бүрийн газраас хүмүүс бидэнд хандаж байна. Ирээчээ, туслаачээ, бидэнд мэдээлэл өгөөч гэж байна. Энэ ажиллагаанд ажлын хэсэг, яамнаас оролцох боломж байна уу? Зүүн болон говийн бүсийн арга хэмжээнд манай байгууллага оролцох бүрэн боломжтой гэдэг саналаа хэлье.

Э.Батболд: Ашигт малтмалын тухай хуулийн төсөл бүрэн нээлттэй байгаа, саналаа өгөх бүрэн боломжтой. Ажлын алба Цолмон гуай хуулийн төслийг явуулж танилцуулаарай, саналыг хүлээж авлаа.

Н.Баярсайхан: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Сүүлийн үед Уул уурхайн яамны мэдээллүүд хаалттай болоод байгаа. Сонгон шалгаруулалт тусгай зөвшөөрөл олгох журмыг шинэчилсэн гэж байгаа боловч журмын төсөл дээр хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу санал авсангүй. Санал авах процесс явагдаж байна уу? Мэдээлэл авахад журам сайдын түвшинд батлагдаад хуулийн мэдээллийн санд бүртгүүлэхээр хүргүүлсэн гэж байгаа. Энэ журам батлагдаагүй байхад орон нутагт лиценз олгоод байна. Дорноговь аймгийн Даланжаргалан сум угаасаа 106 лицензтэй, он гараад дүйцүүлэх лиценз нэртэй гурван лиценз очсон гэнэ. Тэгэхээр энэ журам, зохицуулалт яаж явагдаад байна вэ маш ойлгомжгүй байна. Иймэрхүү мэдээллийг асуух ярилцах хэрэгтэй байна, ижил тэгш мэдээлэл авч чадахгүй байна. Энэ талаар яамныхан хариулж өгнө үү, бидэнд журмын төслийг өгөх үү, одоо ямар түвшинд явж байна?

Э.Батболд: Миний мэдэж байгаагаар журмын төсөл олон нийтээс санал авахаар яамны веб сайтад бүтэн 6 сар болсон, дараа нь 4 сард бүтэн өдрийн семинар хийж танилцуулаад Хууль зүйн яам руу явсан гэж ойлгож байгаа.

Н.Баярсайхан: Өнөөдрийн байдлаар Хууль зүйн мэдээллийн санд бүртгэгдэж, ил болсон уу?

Д.Дамба: Бүртгэгдэж шатандаа явж байгаа гэж ойлгож байгаа, би Геологийн бодлогын газраас тодруулаад эргэж мэдэгдэе.

Т.Цэрэн: Сонгон шалгаруулалттай холбоотой гомдол манай МБОИЗ-ийн зүгээс байна. Нэгдүгээрт, сонгон шалгаруулалт өөрчлөгдөж байгаа гэж мэдээгүй, журамд санал аваагүй. Тусгай зөвшөөрлийг иргэдээс нь асуухгүйгээр шууд олгох процесс явагдаж байгаа юм байна. ОУИТБС нь өөрөө манлайлалтай байж, ажлын хэсэгт орж байгаа ТББ-уудад мэдээллийг ил тод хүргэдэг баймаар байна. Ер нь бол зөвхөн мэдээллийн журмаар зар мэдээг явуулж байгаа, бусдаар мэдээлэл хүргэх, санал авахгүй байгааг хэлмээр байна.

Д.Дамба: Төрийн захиргааны байгууллага, яам агентлагууд өөрийн вебсайт ажиллуулж, хуулийн хугацаанд хэлэлцүүлэг хийх, олон нийтээс санал ажлуудыг

явуулж байгаа. Ялангуяа манай АМГТГ аж ахуйн нэгжүүдэд мэдэгдэж, гол гол бодлогын баримт бичиг, эрхзүйн актууд дээр санал авч байгаа. Тэгэхээр манайхан вэбсайт руу орж, мэдээлэл авч байх нь зүйтэй.

Ц.Бээжин: Цолмон даргын илтгэлд ИНБ-уудийн оролцоог нэмэгдүүлэх, ялангуяа орон нутгийн иргэдэд зөв мэдээлэл өгнө дурдсанд санал нэг байна. Би Өмнөговь аймгийн уугуул, байгаль орчны чиглэлээр 30-аад жил ажиллаж байна. Уул уурхай байгаль орчинд гол нөлөө үзүүлдэг. Иймд уул уурхайг хөгжүүлэхэд нутгийн иргэдийг оролцуулах тэдэнтэй холбоотой байх нь чухал гэж үздэг. Ийм ч учраас МБОИЗ-д нэгдэн ажиллаж байна. ОУИТБС-ын төлөвлөгөөнд гарсан иргэдэд мэдээлэл хүргэх, хамтран ажиллах талаар МБОИЗ-ын хийх боломжтой гэж бодож байна. Манай байгууллага 200 гаруй байгууллагыг нэгтгэсэн, 21 аймагт салбартай томоохон байгууллага юм. Иймд манайтай хамтран ажиллах нь зүгээр юм гэсэн саналтай байна. Мөн нуугдмал өмчлөгчийг ил болгох талаар ярьлаа, үүнийг дэмжиж байна. Мөн говийн бүсийн ил тод байдлын аян хоцрогдолтой байгаа гэж илтгэлд дурдлаа. Энэ үнэн, Өмнөговь аймагт Оюутолгой, Тавантолгой, Нарийн сухайт, Гашуун сухайт хамтдаа стратегийн бүлэг орд буюу стратегийн бүс гэж нэрлэгдэж болно. Зөвхөн Өмнөговь аймагт гэхэд дөрвөн том стратегийн орд байна, мөн бусад олон хайгуул, ашиглалтын компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа. Үүнээс шалтгаалаад тус аймагт олон асуудал гарч байгаа бусад аймгуудтай харьцуулашгүй том үйл ажиллагаа явагдаж байгаа. Иймээс аймаг тус бүрийн онцлогийг харгалзаж, ажлын төлөвлөгөөндөө уялдуулж ажиллавал бодитой болов уу гэсэн саналтай байна. Хоёрдугаарт, говийн бүсийн дэд зөвлөлийн уулзалтыг 5 дугаар сард зохион байгуулах юм байна үүнийг манай МБОИЗ-д хариуцуулаад өгчихвөл бид хийх боломжтой гэж харж байна. Миний хувьд говийн аймгууд болон бусад аймгуудад ажиллаж байгаа уул уурхайтай холбоотой асуудлаар хувийн зүгээр хийсэн судалгаа, шинжилгээ нилээдгүй байгаа. Мөн улсын түвшинд анх удаа УУХҮЯ-наас томилсон Оюутолгой компанийг шалгах ажлын хэсэгт орж ажиллаж, техникийн зөвлөгөө өгөх ажлыг хийж байсан. Оюутолгойд авах ч юм бий, хаях ч юм бий. Хувь хүний зүгээс ийм туршлага байгаа иймд говийн бүсийн аймгуудад зохион байгуулах үйл ажиллагааг манай байгууллагад хариуцуулаад, үүрэгжүүлээд өгчихвөл бид хийх боломжтой гэсэн саналтай байна. Тавдугаар сард олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулах арга хэмжээнд БОАЖЯ, Зам тээврийн яамны нэр байхгүй байна гэж ойлгосон, үүнийг бодож үзээрэй. Дээрх байгууллагууд уул уурхайтай нягт холбоотой гэдгийг анхаарах хэрэгтэй. Уул уурхайн бүтээгдхүүнийг боомтууд руу хүргэхэд тээвэр ложистикийн асуудал хэл амтай, маргаантай байгаа. Шороон замын тээвэрлэлт, уул уурхайн төслүүд рүү хүргэж байгаа тэсрэх бодис, хоол хүнс, шатахуун гэх мэт тээврүүд явж байгаа. Үүнийг зохицуулах, салбар хоорондын уялдааг сайжруулах шаардлага ажиглагддаг. Тэгэхээр цаашдаа ОУИТБС маань БОАЖЯ болон Зам тээврийн яамтай нягт хамтран ажиллах нь зүйтэй юм уу гэж харж байна. Баярлалаа.

Ц.Туяацэцэг: Монголын Байгаль орчны хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, ТАН эвслийн ерөнхий зохицуулагчаар сонгогдоод ажиллаж байна. ТАН эвсэл анхны хурлаа өчигдөр хийсэн, цаашид хийх ажлын төлөвлөгөө 5 дугаар сарын 10-ны хурлаар хийнэ. Цолмон даргын илтгэлд гарсан төрийн байгууллагуудтай хэлэлцүүлэг хийх ажлын дэмжиж байна. Хэзээ, хаана, ямар хэлэлцүүлэг хийж, ямар үр дүнд хүрэх вэ гэдгийг тодорхой болгож байгаад хийхгүй бол үр дүнд хүрэхгүй. Иймийн тулд урьдчилсан ажиллагаануудыг сайн хийж, яаралтай хэд хэдэн удаагийн хэлэлцүүлгийг хийх хэрэгтэй. Зүүн болон говийн бүсийн уулзалт, өдөрлөгийн урьдчилж иргэдэд мэдээлэл хүргүүлж, оролцоог сайн хангаж, өдөрлөгт иргэдийг олноор нь оролцуулах нь зүйтэй. Ялангуяа говийн бүсийн өдөрлөг нэн яаралтай,

чухал асуудал болоод байна гэж харж байна. Уул уурхайтай аймгийн ирээдүйн тавилан нэвтрүүлэгт оролцох гурван аймгийг сонгох юм байна, үүнд: Дорноговь аймгийн Даланжаргалан сум сонгогдсон юм байна, бусад 2 аймагт нь ямар аймаг сонгогдох бол? Оролцогч талуудын оролцоогүйгээр эрх ашиг нь хөндөгдөж байгаа орон нутагт энэ нэвтрүүлэг нилээд бодит үр дүнд хүргэх учраас үлдсэн хоёр аймгууд дээр санал аваад өрсөлдүүлээд, санал авч, бодитой баримтууд дээр үндэслэн шалгаруулаарай гэж хүсье. Хууль тогтоомийн тухай хуульд заахдаа "...орон нутгийн иргэдийн оролцоог хангах, хэрэгжилтийн үр нөлөөнд үнэлэлт өгөх замаар хэрэгжүүлнэ" гэсэн байдаг. Гэтэл уул уурхайн тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтыг эдийн засгийн хямрал, валютын нөөцийг нэмэгдүүлэх нэрийдлээр жилдээ 400-500 тусгай зөвшөөрөл өгнө гэдэг нь ирээдүйд асар их эрсдэлийг дагуулах асуудал болж байгаа. Журмын төсөлд 30 хоногийн дотор санал аваад, Уул уурхайн сайд батлаад Хууль зүйн яамны хуулийн хэлтэст бүртгэгдэж, мэдээллийн санд бүртгэгдэнэ гэж ойлгож байгаа. Энэ талаар ТАН эвсэл, МБОИЗ зэрэг нэгдсэн шүхэр байгууллагуудад ирээгүй, мэдээгүй. Бид олон нийтийн сүлжээнд байгаа мэдээллийн хүрээнд мэдээлэлтэй явж байна. Хэрвээ энэ журмыг Уул уурхайн сайд батласан аваас хууль, шүүхийн хаалга татах аюул занал бий болж байгаа. Монголын Байгаль орчны хуульчдын зөвлөл захиргааны маргаан дээр нилээн олон жил ажиллаж байгаа. Захиргааны маргаанд кадастрын хэлтэс хариуцагчаар орж ирдэг. Төрийг төлөөлж байгаа хэлтэс, газрын даргыг төлөөлж байгаа итгэмжлэгдсэн төлөөлөлч, хуульчдийн мэдлэгийг нэмэгдүүлмээр байна. Шүүх танхимд орж ирчихээд тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй нэгдмэл байр суурийг илэрхийлээд байдаг үүнийг халах хэрэгтэй байна. Тиймээс ойрын хугацаанд Ашигт малтмалын газар, иргэдийг оролцуулсан хэлэлцүүлгийг хиймээр байна. Өнөөдөр сайхан юм ярьж байна харин шүүхийн танхимд юу ярих вэ гэдэг асуудлыг ярих цаг болсон байна. Хууль бус үйлдлээ хууль ёсны болгох гээд байдаг. Бидний яриад байгаа асуудлыг нэгтгэвэл иргэдийн мэдэх эрхийн асуудал явж байгаа. Мэдэх эрхийн асуудал яамдын сайтруу орооч гэдэг байдлаар хязгаарлагдаад байна. Уул уурхайн мэдээллийн сан хангалтгүй байдаг, бид байнга орж мэдээлэл олж авахыг хичээдэг. Кадастрын мэдээллийн сан гайгүй байсан сүүлийн үед маш муу болсон. Тэгэхээр яам болон агентлагт тусгайлан мэдээллийн санг ажиллуулдаг мэдээлэл технологийн инженер, мэргэжилтэнүүд байгаа. Тэд энэ мэдээллийг оруулаагүйгээс үүдэлтэй гэм хор буюу үр дагаврын асуудал дээр яаж хариуцлага тооцдог вэ? Та нар мэдээллийн санруугаа ор гээд байгаа боловч мэдээллийн санд мэдээлэл хууль дүрэмд заасныхаа дагуу байхгүй байгаа. Тэгэхээр энэ мэдээллийн санг яаралтай, сайн ажиллуулах хэрэгтэй байна. ТАН эвслийн хүрээнд яригдаж байгаа асуудлын дунд нээлттэй мэдээллийн платформын асуудлууд байгаа. Тухайлбал, зөрчлийг мэдээлдэг зөвлөх үйлчилгээ үзүүлдэг платформыг ажиллуулах гээд Нээлттэй нийгэм форум туршилтын "Mining watch" ажиллуулсан боловч өнөөдөр хүн хүч, хөрөнгийн асуудлаас болоод төдийлөн бас жигдэрч ороогүй байна. Энэ бол зөвхөн ИНБ-ын хийдэг ажил биш юм. Үнэхээр энэ платформ хэрэгтэй байна. Өнөөдөр Өмнөговь аймгийн Хүрмэн сум, Номгон суманд Цагаан дэлийн боомтод орж ирсэн асуудлууд, зөрчил маргаан, Мандах сумын Довцог худгийн маргааны асуудал өөрөө мэдээлэл байхгүйгээс үүдэж байна. Цагаан дэлийн боомтын цаад эзэд 6-7 тусгай зөвшөөрлийн асуудал байна. Арав гаруй километр газрын хашаалаад ан амьтны коридор, малын бэлчээр зэрэг бусад бүх юмыг хаагаад байна. Малын бэлчээр шав тэмдэг тавьдаг, экскаватороор ухдаг байсан бол өнөөдөр төмөр хашаагаар хашаалдаг болсон байна энэ зөв юм уу? буруу юмуу? гэх мэтчилэн зөрчлүүд байна. Хууль зүйн мэдээллийг өгдөг, зөвлөдөг платформыг ажиллуулахгүйгээр өнөөдөр төлсөн авснаа нийтлэх, ил тод байдлын санаачилга маань хязгаарлагдахгүй болохоор энэ платформоо бид яаралтай ажиллуулах саналтай байна. ТАН-гийн олон улсын эвслээс ил тод байдлын долоо хоногийг зохион байгуулах гэж байна.

Энд бид нэгдсэн нэг төлөвлөгөөтэй орох вэ? Монгол улсын Засгийн газар олон улсын өмнө амласан амлалтаа хэрхэн биелүүлж байгаад бид ямар шахалт шаардлага хүргүүлэх вэ? Тавдугаар сард болох Нээлттэй засаглалыг олон улсын дээд хэмжээний уулзалтанд талууд ямар байр суурьтай оролцох вэ, нэгдсэн ямар нэгэн төлөвлөгөө гаргах уу? энэ асуудлыг бид өнөөдөр гаргаж байж, баялагтаа эзэн байх, баялагийн асуудлынхаа ил тод байдал, төлсөн авсанаа нийтлэх энэ зарчим дээр нилээн том ахиц дэвшил гаргуулах боломж байна гэж харж байна, ийм саналтай байна. Баярлалаа.

Э.Батболд: За баярлалаа өөр санал байхгүй бол дараагийн танилцуулгаа сонсоё.

Танилцуулга гурав: Монголын ОУИТБС-ын оролцогч талуудыг зураглал болон Үндэсний зөвлөл Ажлын хэсгийн дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.

3.Цэлмэг: Сайн байцгаана уу, энэ өдрийн мэндийг хүргэе. Монголын ОУИТБС-ын оролцогч талуудын зураглалыг өмнөх харилцааны мэрэгжилтэн Байгал хийсэн байгаа. Үүнийг товч танилцуулахад, Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн дүрэм, журамд орох нэмэлт өөрчлөлтийн саналаа танилцуулна. Энэхүү зураглалын зорилго нь эрдэс баялагаас олж буй орлогыг олон нийтэд ил тод болгосноор түүнийг нийтийн сайн сайхны төлөө зөв зарцуулахад нь оролцогч талуудын хариуцлагыг өндөржүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэхэд нөлөөлөх хүчин зүй болох. Уул уурхай, олборлох салбар нь 2050 он хүртэл тэргүүлэх салбар хэвээр байх бөгөөд хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшинг нэмэгдүүлнэ. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ил тод уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг өргөжүүлж, эрдэс баялагийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялагийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Уул уурхайн салбарын институцыг бэхжүүлж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, лиценз олголтыг олон нийтэд нээлттэй болгох, хууль зөрчиж олгосон зөвшөөрлийг хүчингүй болгоно. Хайгуулын тусгай зөвшөөрлийг цахимжуулж, эрчимжүүлсэн. Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс хөдөө аж ахуй, аялал жуулчлал, зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбар, мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авахад дэмжлэг үзүүлнэ гэж заасан байдаг. Үүнээс харахад орон нутгийн хөгжлийн асуудал орхигдсон харагдаж байгаа, олон нийтийн мэдэх эрх орхигдсон болов уу үүнээс үүдээд иргэд олон нийтийн үл ойлголцол гарч байгаа. Үүний улмаас ОУИТБС-ын тайлан гаргахгүй тусгай зөвшөөрөл эзэмшигчид нэмэгдээд байгаа. Ил тод байдлаа сайжруулъя, орон нутгийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд оролцогч талуудын оролцоог сайжруулахын тулд бусад орнуудын оролцоог судлаж, төрийн байгууллагын манлайллыг авч үзсэн. Филиппин, ХБНГУ, Нигери, Армени зэрэг улсуудын ОУИТБС-ын талаар харьцуулсан/судалгааг хавсаргав/

Бид ОУИТБС-ын Үндэсний зөвлөл болон Ажлын хэсгийн гишүүдийн идэвх оролцоог үнэлсэн. Үүнээс харахад ИНБ-ийн байгууллагын оролцоо сайн, харин төрийн байгууллага болон компаниудын идэвх оролцоо сул байгаа нь харагдаж байна, үүнийг танилцуулгаас харж болно. Тухайлбал, Үндэсний зөвлөлийн хуралдаанд Төсвийн байнгын хороо сүүлийн 2 жилийн хуралдаанд ороогүй байна, ИНБ-аас Бугант заамар ТББ, МБОИЗ нэг удаа тус тус оролцсон байна. Компаниас Рио Тинто ХХК-ийн төлөөлөл нэг удаа оролцсон байна. Ажлын хэсгийн хуралдаанд Засгийн газрын төлөөлөл байхгүй, орон нутгийн төлөөл байдаг боловч хуралдаанд оролцдоггүй, компаниуд ерөнхийдөө гайгүй орж байгаа, Багануурт ХК ороогүй,

иргэний нийгмийн байгууллагууд жигд оролцсон байна. Харин Бугант заамар, Алт үйлдвэрлэгчдийн холбоо, Эрхүүгийн УААДС төгсөгчдийн холбоо зэрэг байгууллагуудын оролцоо муу байна. /танилцуулга, баримт бичгийг хавсаргав/

Монголын ОУИТБС-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн 16 дугаар хуралдаанаар хэлэлцэн баталсан ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулах санал:

1. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд орох төрийн талын төлөөлөлд орон нутгийн удирдлагыг оруулах бөгөөд түүнийг Үндэсний зөвлөлийн тэргүүн томилж, чөлөөлнө.
2. Үндэсний зөвлөлд санал болгох гишүүд нь Үндэсний зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан гишүүнчлэлийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн байна.
3. Үндэсний зөвлөлийн хуралдаанд хоёр ба түүнээс дээш удаа биечлэн оролцоогүй, оролцох боломжгүй ч хэлэлцэх асуудлын талаар саналаа бичгээр мэдэгдээгүй тохиолдолд гишүүнээс түдгэлзүүлнэ.
4. Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ОУИТБС-ын нээлттэй өгөгдлийн сангийн ашиглалтыг нэмэгдүүлэх, ялангуяа орон нутгийн түвшинд хэрэглээг нь сайжруулах талаар хэлэлцэж, Ажлын албаны дараа оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах.

Монголын ОУИТБС-ыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийн 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан ажиллах журамд:

1. Ажлын хэсэгт санал болгох гишүүд нь Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн баталсан гишүүнчлэлийн шалгуур үзүүлэлтэд нийцсэн байна.
2. Ажлын хэсгийн хуралдаанд 3 ба түүнээс дээш удаа оролцоогүй тохиолдолд бүрэлдэхүүнээс автоматаар хасна. Хэрэв Ажлын хэсгийн гишүүн хуралдаанд биеэр оролцоогүй ч хэлэлцэх асуудлын хүрээнд саналаа бичгээр ирүүлсэн тохиолдолд оролцсонд тооцно.
3. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд гарсан сул орон тоонд шаардлага хангасан гишүүнийг элсүүлж болно.
4. Шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд тал тус бүрийн төлөөллийн 20-30 хувьд бие даасан гишүүн байж болно. Хэрэв бие даасан гишүүн нь аль нэг орон нутгийг төлөөлөх бол давуу тал болно.

Мөн ажлын хэсгийн гишүүдийн эрх, үүргийн хүрээнд ОУИТБС-ын хэрэгжилтийг хангах, ач холбогдлыг олон нийтэд сурталчилсан эсэх, оролцооны талаар талуудын ахлагч нар жилдээ нэг удаа тайлагнадаг байх гэсэн саналуудыг гаргаж байна. Баярлалаа. /Танилцуулгыг хавсаргав/

Э.Батболд: Танилцуулга хийсэн Цэлмэгт баярлалаа, танилцуулгатай холбогдуулан асуух асуулт, саналтай гишүүд байвал ярьж болно.

Д.Эрдэнэчимэг: Үндэсний зөвлөл ажлын хэсгийн ажиллах журамд оруулах нэмэлт өөрчлөлтийн саналыг дэмжиж байна. Гишүүд бүгдээрээ өөрийн байгууллагаа төлөөлж байгаа, ТАН эвслийн төлөөлөл 35 байгууллагыг төлөөлөөд байр сууриа илэрхийлж байгаа, МБОИЗ-ийн төлөөлөл 200 гаруй байгууллагыг төлөөлж байгаа гэх мэтээр тодорхой талуудыг эрх ашгийг илэрхийлж байдаг. Эдгээр гишүүд нь тухайн байгууллагадаа хурлын талаарх мэдээллийг танилцуулах, заримдаа шийдвэр гаргах түвшиний асуудал гарвал хурлаа хийгээд, асуудлыг танилцуулаад

хурлаас гарсан саналыг нэгтгэж эргэж мэдэгдэх байдлаар төлөөллийнхөө эрх, үүргийг хангах зохицуулалтыг нэмж оруулах нь саналтай байна. Ер нь манай ТАН эвсэл аливаа асуудал тухайлбал, ажлын төлөвлөгөө зэрэгт санал өгөхдөө гишүүдтэйгээ хэлэлцээд саналыг аваад нэгтгэж, хариу өгөх, гишүүддээ хэлэлцсэн асуудлын талаар мэдээлэл өгөөд явдаг үүнийгээ албажуулвал зүгээр санагдаж байна. Бусад байгууллага төрийн байгууллагын удирдлагад мэдээлэл хүрэхгүй байгаа зүйл ажиглагдаад байдаг. Үүнийг журамд тусгах саналтай байна. Саналыг томъёолоод имэйлээр хүргүүлж болно. Баярлалаа

Л.Төрмөнх: Хуралдаанд оролцож байгаа бүх хүмүүсийн амгаланг айлтгая. Энэхүү ажиллах журмын саналд нэмэх зүйлгүй, дэмжиж байна. Харин Дэд зөвлөлүүдийн ажиллах журамд байдаг “Дэд зөвлөлийг Засаг даргын орлогч” гэсэн заалтыг өөрчлөх саналыг бүсийн чуулганд тавьж байсан. Тэр саналыг ихэнх оролцогчид дэмжиж байсан боловч өөрчлөгдөөгүй тэр чигээрээ байгаад байна. Гурван талын оролцоо зөвшилцөж байгаад ахлагчаа томилдог болвол ажлын гацаанаасаа гарах боломжтой гэж харж байгаа. Тухайлбал манай Ховд аймагт Засаг даргын орлогч огт хөдлөхгүй, ил тод байдлын ажлыг гацаагаад байдаг. Ажлын төлөвлөгөө боловсруулаад өгнө түүнийг батлахгүй, тэгээд яасан нь мэдэхгүй алга болчихдог. Үүнийг дахин сануулж байна. Талуудыг оролцоог сайн хангаад, мэдээллээ тэгш хүргэж ажиллах талаар анхаараарай. Саяхан хуулийн хэлэлцүүлэг зохион байгуулсан байсан, урьдчилж хэлээгүй хөдөө явж байхад одоо болж байна, ирж оролцооч гэж залгасан. Орон нутагт ажиллаж байгаа ИНБ-уудыг бүртгэлжүүлээд, мэдээллийг урьдчилан тэгш хүргэх хэрэгтэй байна. За баярлалаа.

З.Баярхүү: Энэ судалгаа нь үндэслэл сайтай, сайн судалгаа болсон байна гэж харж байна. Ажлын хэсгийн журамд оруулах өөрчлөлтийн дөрөвдүгээр саналыг арай нарийвчилах нь зүйтэй болов уу гэж харж байна. Тухайлбал, ажлын хэсэгт орж байгаа оролцогч талууд буюу төрийн байгууллага яг ямар үүрэг оролцоотой байх ёстой вэ, ИНБ болон компаниуд яг ямар үүрэг оролцоотой байх вэ? гэдгийг журамд илүү нарийвчлаад тэр үүргийнхээ дагуу хийж чадаж байна уу үгүй юу гэдгээ ярьдаг баймаар байна. Төрийн байгууллагаас Авилгатай тэмцэх газрын Соён гэгээрүүлэх хэлтсийн төлөөлөл орсон байдаг. Соён гэгээрүүлэх гэдэг нь ил тод байдлыг ойлгуулах газар гэж ойлгож болно. Ил тод байна гэдэг нь авилгаас ангид байна гэсэн үг тэгэхээр энэ чиглэлээр ажиллаж болж байна. Мөн АТГ нь манай дата мэдээллийг ашигладаг үүнийг хэрхэн яаж ашигладаг талаар тодорхой хэмжээний тайлан мэдээлэл өгдөг бол зүгээр байна. Ер нь олон улсын сургалт, семинарыг харж байхад ОУИТБС-ын дата мэдээллийг АТГ, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг байгууллагууд өргөн ашигладаг байна. Санхүүгийн мөнгөн урсгал хаашаа яваад байна, өгсөн хандив тусламж зориулалтын дагуу зарцуулагдаж байна уу эсвэл хувьдаа завшиж уу гэдгийг манай тоон мэдээлэл, датаг ашигладаг байдлаар төрийн байгууллагууд ажиллах, гишүүн компаниуд датаг ашиглах тал дээр бусад компаниудаа манлайлах, мэдээлэл түгээх гэх мэтээр нарийвчилвал зүгээр болов уу. Мэргэжлийн хяналтын газар гэхэд Үндэсний зөвлөлийн хуралд тайлан тавих үүрэгтэй байдаг боловч түүнийгээ биелүүлдэггүй. Жилдээ 400-500 компани ил тодын тайлангаа гаргахгүй байдаг эдгээр компаниудад хуулийн дагуу ямар хариуцлага тооцсон гэдгийг Үндэсний зөвлөлийн хурал дээр танилцуулах ёстой ч танилцуулдаггүй тэгэхээр энэхүү үүрэг хариуцлагыг илүү нарийвчилвал зүгээр гэж харж байна. Баярлалаа.

Ц.Туяацэцэг: Үндэсний зөвлөл, Ажлын хэсгийн ажиллах журамд оруулах санал боломжийн, дэмжиж байна. Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд удирдах нь зөв гэсэн саналыг зүйтэй гэж үзэж байна. Чиглэлийн яам нь чиг үүргийнхээ яаманд үүрэг өгөөд

Улсын их хурал руу давж харьцдаг байх нь учир дутагдалтай, хүндрэл бэрхшээлтэй гэж харж байна. Тийм учраас Ерөнхий сайд санаачилгыг удирддаг байсан хуучин байдалд оруулахын тулд нилээд сайн ажиллах ёстой байна. Энэ ажлын хэсэг дотор Сангийн яам байх нь зүйтэй гэж үзэж байгаа. Ер нь яагаад заавал Сангийн яам байх хэрэгтэй вэ гэхээр компаниуд орон нутагтай хамтын ажиллагааны гэрээ байгуулаад гэрээний дагуу өгч байгаа хандив тусламжаас гадна тусгай зөвшөөрлийн төлбөр, газар, ус ашигласны төлбөр хэрхэн зарцуулагдаж байгаа нь Сангийн яамаар хянагдаж байдаг. Түүнээс гадна байгалийн нөөц баялагийг ашигласан, гэмтээсэн, экологийн хохирол, байгаль орчинд үзүүлсэн хохирол зэрэг асуудлуудыг захиргаа болон эрүүгийн журмаар гаргаж ирдэг, хэдэн тэрбум, хэдэн саяар нь шийдвэрлэж байгаа. Жишээлбэл, Эрүүгийн цагдаагийн газар 468 сая төгрөгийн экологийн хохирол учруулсан хэргийг оруулж ирсэн, захиргааны маргаанаар байгаль орчны хохирол 180 сая төгрөгийг бид шийдүүлсэн. Гэхдээ энэ мөнгө Сангийн яамны уур амьсгалын өөрчлөлтийн сан букуу төсөвт ордог тэгээд тэр мөнгөөрөө төсвийн цоорхойг нөхөөд байдаг, тухайн гэмтсэн газар нутгийг сэргээх ажилд зарцуулагдахгүй байна. Тусгай сангийн тухай хуулийн 7-д энэ хөрөнгийг юунд зарцуулах вэ гэдгийг тодорхой заасан байдаг. Тухайлбал, иргэн аж ахуйн нэгжээ урамшуулах, сургалт семинар зохион байгуулах, боловсролыг дээшлүүлэх гэх мэтээр нарийн заасан байдаг. Мөн олборлох компаниудын тусгай санд оруулж байгаа орлогыг зорилтот үйл ажиллагаанд зарцуулахгүй байгаа. Иймээс Сангийн яам ажлын хэсэгт зайлшгүй байх нь зүйтэй. Уул уурхайн нөлөө бүхий орон нутгийн удирдлагуудыг оруулах асуудал яригдаж байна. Ер нь орон нутгийн удирдлагууд шууд Ерөнхий сайдын харъяанд байдаг, тодорхой хугацаатай. Ерөнхий сайд өөрөө удирдаж байгаа тохиолдолд хариуцлага хүлээлгээд явдаг ийм тогтолцоо байгаа. Өнөөдрийн байдлыг харахад хариуцлагын тогтолцоо байхгүйгээс үүнийг алба гэхээсээ илүү зарим нь өөрт ногдсон ял мэтээр явж ирсэн байна, иймээс үүрэг хариуцлагын тогтолцоог сайн оруулж өгөх хэрэгтэй байна. Мөн шалгуур үзүүлэлтэй болгох, хамгийн эхний шалгуур үзүүлэлт нь тайлагнадаг, мэдээлдэг байх юм. Ажлын хэсэгт ороод маш олон хуралд ороод маш олон мэдээлэл аваад явж байгаа ч гэсэн энэ хүмүүсийн ажлын тайланг бид өнөөдөр олж авч, үзэж чадахгүй байна, тухайн байгууллагынхаа өмч болоод явчиж байна. Тэмдэглэл, хийсэн ажлын тайлан цаасаар болон цахимаар харагддаггүй юм байна. Би ТАН эвслийн ажлыг авахад иймэрхүү байдлууд харагдаж байна. Тийм болохоор тайлагнадаг, мэдээлдэг эргэх холбоо нь энэ тайлангийн хамгийн гол шалгуур үзүүлэлт байх юм байна гэж харж байна. Мэдээж ОУИТБС-ыг эерэг харагдуулах, идэвхжүүлэх, оролцоог хангах хэрэгтэй байна үүний тулд шалгуур үзүүлэлт чухал гэж харлаа. Баярлалаа.

Т.Цэрэн: Журмын өөрчлөлтөд Ерөнхий сайдаар ахлуулна гэдэг нь маш зөв байна. Харин үүнийг хэрхэн яаж хурдтайгаар хийж, баталгаажуулах нь зүйтэй энэ ажилдаа яаравчлан орох нь зүйтэй байна. Мөн Мэргэжлийн хяналтыг оруулах саналтай байна. Хэн ямар дүрэм журам зөрчөөд байгаа, түүнд ямар хариуцлага тооцсон тухай мэдээлэл олон нийтэд байдаггүй, иймд Мэргэжлийн хяналтын газар байх нь зүйтэй. Хариуцлагын тогтолцоо гэдэг нь зөв гэхдээ оролцох хөшүүрэг нь юу байх вэ гэдгийг бодож үзэх нь зөв байх. Жишээлбэл, дэд зөвлөлүүд хангалтгүй ажиллаж байна гэдэг дүгнэлт гарсан байна. Хангалтгүй ажиллаж байгаа хэд хэдэн шалтгаан байгаагаас хамгийн өндөр хувь авсан нь санхүүжилт дутмаг байна гэж байна. Тэгэхээр Үндэсний зөвлөл маань санхүүжилт тогтвортой байх юм уу, энэ санхүүжилтээсээ бусад газруудад тусгаж өгөх боломжтой байдаг уу, гишүүдээ хүртэл идэвхжүүлэх, оролцоог хангах дээр ямар хөшүүрэг байвал зүгээр вэ? яах вэ гурван удаа оролцоогүй бол гишүүнээс хасах тухай санал яригдаж байна. Энэ нь нэг талаараа зөв ч гэсэн нөгөө талаараа цаашдаа тогтвортой ажиллах, мэдээлэл нэгдсэн ойлголттой байх гэдэг дээр зөрөлдөөн үүсээд цаашид үйл ажиллагаа

хурдтай явахад саад үзүүлэх юм болов уу гэсэн саналтай байна, харгалзан үзэх байх гэж бодож байна, баярлалаа.

Д.Дамба: ОУИТБС 2018 онд УУХҮ-ийн яаманд ирсэн, манай яам чиглэлийн яам байгаа. Тэгэхээр Сангийн яам толгойлох нь зүйтэй гэсэн санал байна. УУХҮЯ Үндэсний зөвлөлийг ахлаад явж байгаа ч ажлын хажуугаар хавсарга байдлаар цалин мөнгөгүй, нэг мэргэжилтэн хариуцан хийж байгаа. Сангийн яам нь анхны таван яамны нэг, бүтэц нь тогтвортой байдаг. Ерөнхий чиг үүргийн яам нь ОУИТБС-ын толгойлох нь зөв болов уу. Харин Үндэсний зөвлөлийн дэд дарга гэж байгуулаад үүнийг уул уурхайн асуудал эрхэлсэн сайд, эдийн засаг юмуу байгаль орчны асуудал эрхэлсэн сайдууд ороод гол үйл ажиллагаагаа хариуцаад гол асуудлаа Үндэсний зөвлөлийн хурлаар шийдвэрлэдэг байх боломжтой гэсэн саналтай байна, баярлалаа.

Ш.Цолмон: МХЕГ ажлын хэсгийн бүрэлдхүүнд байдаг, энэ асуудлыг мэдэж байгаа гагцхүү хуралд оролцох, оролцохгүй асуудал байгаа, хойрго хандаж байсан. Одоогийн удирдлага шинэчлэгдсэн тэгэхээр ойрын үед албан тоот явуулж, мэдээлэл хүргүүлээд, тайлан тавиулах талаар албан хүсэлт гаргая. Хуралд оролцогч, ахлагч нар тухайн төлөөлөө мэдээллээр хангах, саналыг танилцуулах талаар одоогийн журамд байхгүй байгаа үүнийг зайлшгүй оруулах нь зүйтэй байна. Ер нь тухай оролцогч талын төлөөллийн ахлагч гэж байдаг, тухайлбал Ажлын хэсэг дээр компанийн төлөөллийн ахлагч нь Уул уурхайн үндэсний ассоциаци, Үндэсний зөвлөл дээр ерөнхийлөгч нь гэх мэтээр байдаг. Тэгэхээр МБОИЗ болон ТАН гэсэн хоёр эвсэл байгаа хоорондоо ахлагчийн асуудлаа ярьж тохирсон нь зөв байх. Засгийн газрын тогтоол дээр" ОУИТБС-ын дэд зөвлөлийн дарга тухайн аймгийн Засаг даргын орлогч байна" гэж заасан байдаг энэхүү тогтоолыг дагаж гарсан Дэд зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм байгаа үүнд түүнийг заавал тийм байх албагүй, аймгууд өөрсдөө зохицуулах боломжтой байгаа. Иймээс талууд өөрсдөө санал санаачилгатай байвал болох асуудал юм. Өөрөөр хэлбэл заавал Засгийн газрын тогтоолыг баримтлахгүйгээр үлгэрчилсэн дүрмээр дэд зөвлөлийн даргаа сонгох томилоод ээлж дугаартай хамтарч ажиллаж болно. Ер нь энэ журмын өөрчлөлтийг Эрдэс баялагийн ил тод байдлын тухай хуулийн төсөлтэй холбож хийх нь зүйтэй болов уу гэсэн бодолтой байна. Тэгэхгүй бол журмаа өөрчилчихдөг гэтэл хууль нь өөрөөр гарчихвал дараа нь засах, сайжруулах өөрчлөх асуудал гарч магадгүй. Тийм учраас ойрын үед хуулийн төслийн талаар УУХҮ-ийн сайдтай уулзах шаардлагатай байна. Би хувь хүнийхээ хувиар сайдын нарийн бичиг дээр орсон, хүлээж бай, цаг товлоод эргээд хэлнэ гэсэн байгаа. Тэр үед нь зарлаад оролцогч талуудаас нэг нэг төлөөлөл ч юм уу томилоод сайдтай уулзаж, хуулийн төслийн талаар нэг ойлголттой болох саналтай байгаа. Түүнээс ямар яам, сайд удирдахыг дээд шатны байгууллагаас гарсан зөвлөмж саналын дагуу шийдэх байх, тиймээс өөрсдийнхөө зүгээс хийх боломжтой зүйлийг хийх нь зүйтэй гэсэн саналтай байна, баярлалаа.

Ц.Даваасүрэн: Саналуудыг дэмжиж байна, төр засгийн төлөөлөл маш завгүй олон ажлын хэсгийн төлөөлөл байдаг иймээс ажлын алба өөрөө чадавхижиж ажлыг явуулах нь зүйтэй гэж харж байна. Аймгийн засаг дарга, сайд нарын ажлыг үнэлдэг Үр дүнгийн гэрээнд ил тод байдлын ажлыг оруулчихвал илүү тогтвортой, хөшүүрэг болох болов уу гэсэн саналтай байна.

Ц.Бээжин: Аймгуудад Иргэний танхим гэж байдаг, сум, аймгийн Засаг даргын тамгын газарт. Тэнд ил тод байдлын мэдээллийг байршуулж, иргэдэд мэдээлэл өгөх чиглэлээр хамтран ажиллах боломжтой гэсэн санал байна.

3.Цэлмэг: Журмын өөрчлөлтөд хувийн хэвшил, компанийн төлөөлөл саналаа хэлнэ үү.

Б.Батболд: Өнөөдрийн ажлын хэсгийн 58 дугаар хуралдаан маш чухал ажил хэрэгч хурал боллоо. Гишүүд идэвхтэй оролцож тулгамдаж байгаа асуудал санал, зөвлөмжийг хэллээ. Хурлын тэмдэглэлд тусгаад, баталгаажуулаарай. Саналаа хэлж чадаагүй гишүүдээс бичгээр саналыг нь аваад тусгах боломжтой. Өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна, хуралдаа идэвхтэй оролцсон Та бүхэнд баярлалаа.

Хуралдаан 12.00 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэлтэй танилцсан:

УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн
дарга:

 Г.Нандинжаргал

Хуралдааныг даргалсан:
УУХҮЯ-ны СХОГазрын дарга

 Э.Батболд

Тэмдэглэлийн хянасан:
ОҮИТБС-ын Ажлын албаны зохицуулагч

 Ш.Цолмон

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ОҮИТБС-ын Ажлын албаны
Санхүүгийн ажилтан

 А.Отгонтунгалаг